

Анги:

Нэр:

Металлын идэвхийн эгнээ хичээлийн дасгал даалгавар



1. Натри, кали, хөнгөнцагаан, цайр гэсэн элементүүд устай урвалд орох идэвхи хамгийн багатайг сонгоно уу.

A.Натри

B.Кали

C.Хөнгөнцагаан

D.Цайр

2. Идэвхтэй металлаар хийсэн эд зүйлсийг ямар металлаар бүрж хэрэглэж болохыг сонгоно уу.

A. Натри

B.Хөнгөнцагаан

C.Төмөр

D.Зэс

3. Цайр, зэс, натри, кальци гэсэн элементүүд өгөгджээ.Дээрх элементүүдийн химийн тэмдгийг бичээд химийн идэвхи буурах дарааллаар жагсаагаарай

Цайр

Зэс

Натри

Кальци

Идэвхи сайтай

.....

.....

Идэвхи багатай

4. Дараах урвалын үгэн тэгшитгэлийг гүйцээж бүтээгдэхүүн бодисуудыг нэрлэнэ үү?

Зэсийн нитрат + цайр = +

A. Зэс + цайрын нитрат

B. Зэсийн нитрат + цайрын нитрат

C. Урвалд орохгүй

D. Зэс + цайрын сульфат

5. Дараах илэрхийлэл үнэн худал эсэхийг тогтоож бичих .

Илэрхийлэл	Үнэн \ худал
a .Натри хамгийн их идэвхтэй металл	
b. Зэс байгаль дээр нэгдлийн хэлбэрээр оршдог	
c. Цайр нь зэсийг нэгдлээс нь халж чаддаг	
d. Төмөр зэсийг нэгдлээс нь халж чадна.	

6. P, Q, R гэсэн 3 металл дээр хүхрийн хүчил ба усыг нэмэхэд гарсан үр дүнг хүснэгтээр харуулжээ.

Металл	Хүхрийн хүчил	Ус
P	Устөрөгч үүссэн	Устөрөгч үүссэн
Q	Урвалд орохгүй	Урвалд орохгүй
R	Устөрөгч үүссэн	Урвалд орохгүй

Металлуудыг идэвхээр нь зөв жагсаасан эгнээ сонгоно уу.

Идэвхи ихтэй → Идэвхи султай			
A	P	R	Q
B	P	Q	R
C	R	Q	P
D	R	P	Q

7. Идэвхийн эгнээнд устөрөгчийг яагаад байрлуулдаг вэ?

.....

8. Доорх үгэн тэгшитгэлийг гүйцээж эх ба бүтээгдэхүүн бодисыг зөв харгалзуулна уу?

Эх бодис
Цайр + Төмрийн сульфат →
Төмөр + Хартугалганы нитрат →
Цайр + Хартугалганы нитрат →
Цайр + Магнийн хлорид →

Бүтээгдэхүүн бодис
Цайрын нитрат + Хартугалга
Урвалд орохгүй.
Цайрын сульфат + Төмөр
Төмрийн нитрат + Хартугалга